



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 09 дүгээр сарын 23 өдөр

Дугаар 48

Хэрлэн сум

ХХХХVIII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 48 дугаар хуралдаан 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 11:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 83,3 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Чойбалсан хотын "Чойбалсан" зочид буудалд тусгаарлалт ажиглалтад байгаа "ДБЭХС" ТӨХК-ийн хүчин чадлыг 50МВт-аар өргөтгөх төслийн ажлыг гүйцэтгэх БНХАУ-ын 2 дахь ээлжийн 27 ажилчдыг тусгаарлалтаас гаргах талаар хэлэлцэх,

Эрүүл мэндийн газар

2."Шинь шинь" ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийг танилцуулж, шийдвэр гаргуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

3.Дорнод аймгийн Халхгол сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг "Зэст өндөр" ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийг хэлэлцэх,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

4.Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн тайланг танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Д.Мөнхтуяа,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Ч.Оюунаа,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,

цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт:

1.1.Чойбалсан хотын "Чойбалсан" зочид буудалд тусгаарлалтад байгаа "ДБЭХС" ТӨХК-ийн хүчин чадлыг 50МВт-аар өргөтгөх төслийн ажлыг гүйцэтгэх БНХАУ-ын 2 дахь ээлжийн 27 ажилчдын 21 хоногийн тусгаарлан ажиглах хугацаа

дууссан тул тусгаарлалтаас гаргахыг аймгийн Онцгой комиссын гишүүдийн 100 хувийн саналаар зөвшөөрөв,

1.2."Чойбалсан" зочид буудал болон тусгаарлалтаас гарах иргэдийг тээвэрлэх автомашинд коронавирус болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ариутгал халдваргүйтгэл хийхийг,

Хоёр.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт:

2.1.БНХАУ-аас "Замын-Үүд" олон улсын хилийн боомтоор орж ирэх "Шинь Шинь" ХХК-ийн 30 ажилчдыг Чойбалсан хотын "Чойбалсан" зочид буудлын тусгаарлах байранд 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдрөөс хүлээн авч 21 хоног тусгаарлаж, хяналт тавьж ажиллахыг,

2.2.Тусгаарлах байрны камерын хяналт, харуул хамгаалалтын бэлэн байдлыг хангаж ажиллахыг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-т:

2.3.Хөдөлмөрийн гэрээний дагуу тус аймагт хөдөлмөр эрхлэхээр ирж байгаа гадаад иргэдийн судалгаа, мэдээллийг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас тодруулж, аймгийн Онцгой комиссын 49 дүгээр хуралдаанд танилцуулахыг,

Гурав.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-т:

3.1."Зэст өндөр" ХХК-ийн хүсэлтийг хэлэлцэж, мэргэжлийн байгууллагуудын саналын дагуу ариутгал, халдваргүйтгэлийн тоног төхөөрөмжийг хилийн боомтод суурилуулах, хилийн боомтод ажиллах алба хаагчдын ажиллах нөхцлийг бүрдүүлж, халаалт дулааныг бүрэн шийдвэрлэсний дараа уг боомтыг нээх боломжтой талаарх саналыг Улсын Онцгой комисст албан бичгээр уламжлахыг,

Дөрөв.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-т:

4.1.Аймгийн Онцгой комиссын 2020 оны 30 дугаар хуралдааны шийдвэрийн 2.2-т заасан Автотээврийн төвд Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн сангаас 100,000 төгрөгийг зарцуулах эрх олгосон шийдвэрийг хүчингүй болгохыг,

4.2.Аймгийн Онцгой комиссын 2020 оны 45 дугаар хуралдааны 2 дугаар заалтад тусгасан БОЭТ-ийн Халдварт мэдээгүйжүүлэг, Эрчимт эмчилгээ, Хүүхдийн сэхээн амьдруулах тасгуудад ханын хүчилтөрөгчийн систем байгуулахад шаардагдах 8.376.980 төгрөгийг санхүүжилтийг өөрчилж, 6,298,760 төгрөгийн зардлыг Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн сангаас Бүсийн оношлогоо эмчилгээний төвд олгохыг,

4.3.БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгаас Монгол Улсын хөрш зэргэлдээ аймгуудад хүмүүнлэгийн тусламжаар олгосон ариутгалын бодисыг Сүхбаатар аймгаас татан авах тээврийн хэрэгслийн шатахууны зардалд шаардагдах 480,000 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн сангаас Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газарт олгохыг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах, АЗДТГ-ын Олон нийттэй харилцах албаны дарга Э.Батболд нарт

4.4.Дэлхий дахинд Коронавируст халдвар /COVID-19/ гарсантай холбогдуулан аймгийн Онцгой комисст хандив өгсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг алдаршуулах, хүндэтгэл үзүүлэх талархалын "Баярлалаа" арга хэмжээг 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 11:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд зохион байгуулахыг,

Тав.Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат-д:

5.1.Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах ажилд зарцуулахад шаардагдах 200,0 сая төгрөгийг аймгийн 2021 оны төсөвт тусгуулахыг,

Зургаа.Онцгой комиссын нийт гишүүдэд:

6.1.Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын тогтоол, шийдвэр гарсантай холбогдуулан орон нутагт хэрэгжүүлэх үүргийг аймгийн Онцгой комиссын хуралдаанаар албан ёсны шийдвэр гараагүй байхад холбогдох байгууллагаас бие дааж шийдвэр гаргасан албан тушаалтанд хариуцлага оногдуулахыг тус тус үүрэг болгож байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА М.БАДАМСҮРЭН



ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ПРОГРАММ,
ТЕХНИК ХАНГАМЖ ХАРИУЦСАН ИНЖЕНЕР,
АХМАД Э.ГАНЖИГҮҮР